

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/49/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Т.Амармэнд
Утас: 70453721, Цахим хаяг: Amarmendt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.17 № УВА-2022/49/НА-СТА-ТМС
танай _____-ны № _____-т

УС ЦАГ УУР, ОРЧНЫ
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГА Б.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200200217

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	156,308,353.94	243,874,074.94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31210	Төгрөг	0.00	0.00
31211	Төрийн сангийн харилцах	0.00	0.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	156,308,353.94	243,874,074.94
35100	Түүхий эд материал	149,896,279.24	238,071,000.24
35110	Тусгай зориулалттай материал	149,896,279.24	238,071,000.24
35400	Хангамжийн материал	6,412,074.70	5,803,074.70
35420	Аж ахуйн материал	6,412,074.70	5,803,074.70
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,130,725,915.61	2,117,409,828.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,130,725,915.61	2,117,409,828.16
39200	Биет хөрөнгө	1,617,231,915.61	1,603,475,272.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,819,939,849.00	1,819,939,849.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-413,978,416.95	-452,551,111.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,837,420.78	71,867,573.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,247,707.95	-16,464,618.35
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	651,720,384.85	309,540,919.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	-510,009,126.74	-135,329,900.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,525,653.69	6,818,500.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-19,702,141.07	-3,491,938.30
39217	Ном	3,146,000.00	3,146,000.00
39300	Биет бус хөрөнгө	513,494,000.00	513,934,555.56
39301	Программ хангамж	1,392,500.00	1,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-462,500.00	-529,444.44
39303	Бусад биет бус хөрөнгө	512,564,000.00	512,564,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,287,034,269.55	2,361,283,903.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
41300	Өглөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,287,034,269.55	2,361,283,903.10
51	Засгийн газрын хувь оролцоо	2,287,034,269.55	2,361,283,903.10
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,016,818,934.41	1,016,818,934.41
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	1,016,818,934.41	1,016,818,934.41
51200	Хуримтлагдсан үр дүн	1,114,146,688.95	1,247,787,484.50
51210	Өмнөх үеийн үр дүн	1,114,146,688.95	1,173,537,850.95
51220	Тайлант үеийн үр дүн		74,249,633.55
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	156,068,646.19	96,677,484.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,287,034,269.55	2,361,283,903.10

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,907,845,371.57	1,621,254,401.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	455,145,378.57	263,966,943.37
120	Нийтлэг татварын бус орлого	455,145,378.57	263,966,943.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,000.00	467,097.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000.00	467,097.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	177,389,812.78	70,880,525.02
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	277,485,565.79	192,619,321.35
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,452,699,993.00	1,357,287,458.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,389,542,500.00	1,330,323,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,389,542,500.00	1,330,323,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,157,493.00	26,963,858.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,313,870.00	4,437,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,843,623.00	22,525,900.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,833,905,849.89	1,546,627,584.53
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,833,905,849.89	1,546,627,584.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,736,125,901.03	1,492,305,152.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,004,824,987.55	999,311,597.00
210101	Үндсэн цалин	729,402,502.56	727,204,743.00
210102	Нэмэгдэл	245,620,500.00	247,817,416.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,801,984.99	24,289,438.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,885,054.49	131,480,611.00
210201	Тэтгэврийн даатгал	94,959,720.09	91,279,094.88
210202	Тэтгэмжийн даатгал	10,050,900.00	9,219,616.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,040,800.00	8,870,420.08
210204	Ажилгүйдлийн даатгал	2,010,200.00	2,009,582.26
210205	Эрүүл мэндийн даатгал	19,823,434.40	20,101,897.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,431,182.10	51,697,521.64
210301	Гэрэл, цахилгаан	6,368,122.00	6,423,295.64
210302	Түлш, халаалт	43,102,089.10	42,371,226.00
210303	Цэвэр, бохир ус	2,960,971.00	2,903,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,726,263.00	16,116,514.87
210401	Бичиг хэрэг	1,907,700.00	2,968,900.00

210402	Тээвэр, шатахуун	12,233,770.00	7,586,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,526,393.00	2,191,774.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,058,400.00	3,369,000.00
2105	Нормативт зардал	728,600.00	728,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,600.00	728,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,496,350.00	3,139,600.00
210604	Урсгал засвар	2,496,350.00	3,139,600.00
2107	Томилолт, зочны зардал	8,964,700.00	3,816,000.00
210702	Дотоод албан томилолт	8,964,700.00	3,816,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,023,707.00	80,875,858.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,415,500.00	74,070,378.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	660,000.00	1,104,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	128,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,380.00	89,880.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	736,600.00	586,500.00
210807	Газрын төлбөр	4,825,227.00	4,840,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	434,045,056.89	205,139,449.53
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	358,451,218.90	121,005,020.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,300.00	315,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,278,537.99	83,819,429.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	97,779,948.86	54,322,432.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,113,567.00	44,049,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,243,567.00	43,949,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	870,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,666,381.86	10,272,932.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,658,248.86	10,271,935.49
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	8,133.00	996.81
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	73,939,521.68	74,626,816.84
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	377,183.29
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	377,183.29
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	73,939,521.68	74,249,633.55

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,497,402,259.00	1,357,754,555.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	270,000.00	467,097.00
120	Нийтлэг татварын бус орлого	270,000.00	467,097.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	270,000.00	467,097.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	270,000.00	467,097.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,497,132,259.00	1,357,287,458.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,389,542,500.00	1,330,323,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,389,542,500.00	1,330,323,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	63,157,493.00	26,963,858.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	38,313,870.00	4,437,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,843,623.00	22,525,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	44,432,266.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	44,432,266.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,454,660,359.00	1,357,754,555.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,454,660,359.00	1,357,754,555.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,312,448,144.14	1,303,432,122.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,004,824,987.55	999,311,597.00
210101	Үндсэн цалин	729,402,502.56	727,204,743.00
210102	Нэмэгдэл	245,620,500.00	247,817,416.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,801,984.99	24,289,438.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	134,885,054.49	131,480,611.00
210201	Тэтгэврийн даатгал	94,959,720.09	91,279,094.88
210202	Тэтгэмжийн даатгал	10,050,900.00	10,050,001.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,040,800.00	8,040,035.72
210204	Ажилгүйдлийн даатгал	2,010,200.00	2,009,582.26
210205	Эрүүл мэндийн даатгал	19,823,434.40	20,101,897.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,431,182.10	51,697,521.64
210301	Гэрэл, цахилгаан	6,368,122.00	7,073,395.64
210302	Түлш, халаалт	43,102,089.10	41,721,126.00
210303	Цэвэр, бохир ус	2,960,971.00	2,903,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,058,263.00	16,372,414.87
210401	Бичиг хэрэг	1,907,700.00	2,956,400.00
210402	Тээвэр, шатахуун	12,233,770.00	7,761,840.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,526,393.00	2,191,774.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,390,400.00	3,462,400.00
2105	Нормативт зардал	728,600.00	728,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,600.00	728,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,496,350.00	2,272,700.00

Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	198,000.00
210604	Урсгал засвар	2,496,350.00	2,074,700.00
2107	Томилолт, зочны зардал	8,964,700.00	3,816,000.00
210702	Дотоод албан томилолт	8,964,700.00	3,816,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,023,707.00	81,075,858.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,415,500.00	74,270,378.19
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	660,000.00	1,104,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	198,000.00	128,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,380.00	89,880.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	736,600.00	586,500.00
210807	Газрын төлбөр	4,825,227.00	4,840,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,035,300.00	16,677,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,720,000.00	16,362,420.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,300.00	315,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	142,212,214.86	54,322,432.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	136,545,833.00	44,049,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	44,432,266.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,243,567.00	43,949,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	870,000.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,666,381.86	10,272,932.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,666,381.86	10,272,932.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>42,741,900.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	42,741,900.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	42,741,900.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	42,741,900.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	42,741,900.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-42,741,900.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,015,466,934.41	169,395,999.19	1,026,879,814.27	2,211,742,747.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	13,327,353.00	13,327,353.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,015,466,934.41	169,395,999.19	1,040,207,167.27	2,225,070,100.87
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-13,327,353.00	0.00	-13,327,353.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,352,000.00	0.00	0.00	1,352,000.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	73,939,521.68	73,939,521.68
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,016,818,934.41	156,068,646.19	1,114,146,688.95	2,287,034,269.55
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,016,818,934.41	156,068,646.19	1,114,146,688.95	2,287,034,269.55
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	59,391,162.00	59,391,162.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,016,818,934.41	156,068,646.19	1,173,537,850.95	2,346,425,431.55
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-59,391,162.00	0.00	-59,391,162.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	74,249,633.55	74,249,633.55
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,016,818,934.41	96,677,484.19	1,247,787,484.50	2,361,283,903.10

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,330,523,600.00	1,320,518,761.51	10,004,838.49	99.2%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,330,523,600.00	1,320,518,761.51	10,004,838.49	99.2%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,286,574,100.00	1,276,569,261.51	10,004,838.49	99.2%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,005,095,800.00	999,311,597.00	5,784,203.00	99.4%
210101	Үндсэн цалин	727,204,900.00	727,204,743.00	157.00	100%
210102	Нэмэгдэл	247,818,200.00	247,817,416.00	784.00	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,072,700.00	24,289,438.00	5,783,262.00	80.8%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	135,688,000.00	131,480,611.00	4,207,389.00	96.9%
210201	Тэтгэврийн даатгал	95,484,100.00	91,279,094.88	4,205,005.12	95.6%
210202	Тэтгэмжийн даатгал	10,051,000.00	10,050,001.05	998.95	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,040,800.00	8,040,035.72	764.28	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,010,200.00	2,009,582.26	617.74	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	20,101,900.00	20,101,897.09	2.91	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	48,112,800.00	48,112,731.64	68.36	100%
210301	Гэрэл, цахилгаан	7,073,400.00	7,073,395.64	4.36	100%
210302	Түлш, халаалт	38,136,400.00	38,136,336.00	64.00	100%
210303	Цэвэр, бохир ус	2,903,000.00	2,903,000.00		100%
2104	Хангамж, бараа материалын зардал	11,745,500.00	11,744,714.87	785.13	100%
210401	Бичиг хэрэг	2,106,400.00	2,106,400.00		100%
210402	Тээвэр, шатахуун	4,844,700.00	4,844,540.00	160.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,642,400.00	1,641,774.87	625.13	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,152,000.00	3,152,000.00		100%
2105	Нормативт зардал	728,600.00	728,000.00	600.00	99%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	728,600.00	728,000.00	600.00	99%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,272,700.00	2,272,700.00		100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	198,000.00	198,000.00		100%
210604	Урсгал засвар	2,074,700.00	2,074,700.00		100%
2107	Томилолт, зочны зардал	2,338,500.00	2,328,000.00	10,500.00	99.6%
210702	Дотоод албан томилолт	2,338,500.00	2,328,000.00	10,500.00	99.6%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,276,900.00	80,275,907.00	993.00	100%

Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	73,470,500.00	73,470,427.00	73.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,104,800.00	1,104,800.00		100%
210803	Даатгалын үйлчилгээ	128,700.00	128,700.00		100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	89,900.00	89,880.00	20.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	55,000.00		100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	587,400.00	586,500.00	900.00	99.8%
210807	Газрын төлбөр	4,840,600.00	4,840,600.00		100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	315300.00	315000.00	300.00	99.9%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	315,300.00	315,000.00	300.00	99.9%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43949500.00	43949500.00		100%
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00		
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,949,500.00	43,949,500.00		100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	43,949,500.00	43,949,500.00		100%
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00		
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	00.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,330,524,400.00	1,330,790,697.00	-266,297.00	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,330,324,400.00	1,330,323,600.00	800.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,330,324,400.00	1,330,323,600.00	800.00	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	467,097.00	-266,097.00	233.5%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	467,097.00	-267,097.00	223.5%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00		
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00		100%
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00		100%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	88.00	88.00		100%
620001	Удирдах ажилтан	07.00	07.00		100%
620002	Гүйцэтгэх ажилтан	77.00	77.00		100%
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00		100%
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	88.00	88.00		100%

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		26,962,861.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ		26,962,861.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		26,862,861.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		3,584,790.00
210302	Түлш, халаалт		3,584,790.00
2104	Хангамж, бараа материалын зардал		4,627,700.00
210401	Бичиг хэрэг		850,000.00
210402	Тээвэр, шатахуун		2,917,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		550,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		310,400.00
2105	Нормативт зардал		00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		00.00
2107	Томилолт, зочны зардал		1,488,000.00
210702	Дотоод албан томилолт		1,488,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		799,951.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		799,951.19
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		16362420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		16,362,420.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		100000.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		100,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		26963858.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		26,963,858.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,437,958.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		22,525,900.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв нь Ус, цаг уур, орчны мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн ерөнхий газраас үйл ажиллагаанд хяналт мониторинг хийсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтэс эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 7,335.6 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,546,627.5 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 7,733.1 мянган төгрөгийн 80 хувиар буюу 6,186.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,249.7 мянган төгрөгөөр буюу 56.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Бараа материал	156,308.3	243,874.1	87,565.8
Үндсэн хөрөнгө	2,130,725.9	2,117,409.8	-13,316.1
Нийт хөрөнгө	2,287,034.2	2,361,283.9	74,249.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,287,034.2	2,361,283.9	74,249.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,287,034.2	2,361,283.9	74,249.7

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 243,874.1 мянган төгрөг болж 87,565.8 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материалын бараа байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,117,409.8 мянган төгрөг болж 13,316.1 мянган төгрөгөөр буурсан нь 120 нэр төрлийн 220,134.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан, 21 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж дахин шинэчлэн тогтоож, 1,864.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлэн авсантай холбоотойгоор буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,361,283.9 мянган төгрөг болж 74,249.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 286,590.9 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгө, бараа материалын данс байна. Энэ нь үндсэн хөрөнгө данс буурсан, тусгай зориулалттай материалын данс өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 95,412.5 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар буурсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх зардлууд байна.

Тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга 59,391.1 мянган төгрөгөөр хийгдсэн нь үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж дахин шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,602,487.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,602,487.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 307,987.2 мянган төгрөгөөр бууруулан 1,294,499.8 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 36,023.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,330,523.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,330,324.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 200.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,330,323.6 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 467.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,320,518.7

мянган төгрөгийг зарцуулж 10,004.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 10,004.8 мянган төгрөг буюу 99.2 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн байгаль хамгаалах сангаас цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх ажлын санхүүжилт 20,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 4,437.9 мянган төгрөг, давсан орлогоос Сангийн сайдын тушаалаар 2,525.9 мянган төгрөг нийт 26,963.8 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Увс аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцорсон 1, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АМАРМЭНД/

2022 оны 02 сарын 17-ны өдөр